ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: АХГ-2022/225/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
**Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn**
**Аудитын менежер: Б.Сэржмядаг**
**Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn**
**Ахлах аудитор: Б.Нарангэрэл**
**Утас: 261628 Цахим хаяг: narangerelba@audit.gov.mn**
**Аудитор: Н.Баттөгөлдөр**
**Утас: 260512 Цахим хаяг: battuguldurn@audit.gov.mn**

Улаанбаатар хот
2022 он

**Агуулга**

1.Аудитын санал дүгнэлт ... 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 8
3. Аудитын тайлан ... 9
3.1 Ерөнхий зүйл ... 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ... 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ... 10
3.4 Материаллаг байдал ... 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ... 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ... 12
3.8 Аудитын гол асуудал ... 12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ... 13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ... 13
4. Аудитын илрүүлэлт ... 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ... 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НҮБ | Нэгдсэн үндэсний байгууллага |
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ХХК | Хязгаарлагдмал хувьцаат компани |
| ХЧТА | Хөдөлмөрийн чадвар түр алдсан |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/362
танай ______________-ны № ______________-т

ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.ӨНӨРБАЯР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
9019120396

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | **1,012,075,530.15** | **327,551,860.50** |
| **33** | **АВЛАГА** | **174,311,072.00** | **153,576,908.00** |
| 33300 | Татаас санхүүжилтийн авлага | 167,765,030.00 | 64,038,058.00 |
| 33500 | Бусад авлага | 6,546,042.00 | 89,538,850.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 6,546,042.00 | 89,538,850.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **88,627,625.00** | **36,588,000.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 88,627,625.00 | 36,588,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **211,957,533.15** | **107,386,952.50** |
| 35400 | Хангамжийн материал | 211,957,533.15 | 107,386,952.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 58,516,329.09 | 32,099,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 36,813,105.74 | 25,382,520.11 |
| 35430 | Сэлбэр хэрэгсэл | 694,000.00 | 1,344,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,086,587.80 | 3,137,746.65 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 114,847,510.52 | 45,423,385.74 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | **537,179,300.00** | **30,000,000.00** |
| 36900 | БЗЭ буй эргэлтийн бус хөрөнгө | 537,179,300.00 | 30,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | **7,275,314,936.97** | **6,986,298,197.97** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7,275,314,936.97 | 6,986,298,197.67 |
| **392** | **Биет хөрөнгө** | 5,219,936,175.89 | 5,408,350,590.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,728,716,115.00 | 3,728,716,115.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл- Барилга | (186,435,805.68) | (279,653,708.52) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 467,146,300.00 | 483,406,468.19 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл- Тээврийн хэрэгсэл | (263,912,762.12) | (219,503,527.30) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 2,495,933,768.34 | 2,722,603,133.28 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл- Тоног төхөөрөмж | (1,363,172,910.45) | (1,354,827,470.18) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 642,105,439.80 | 601,370,838.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл- Тавилга | (374,331,143.00) | (342,467,387.52) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 73,143,374.00 | 73,143,374.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл- Бусад үндсэн хөрөнгө | - | (5,181,044.28) |
| 39217 | Номын фонд | 743,800.00 | 743,800.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **2,055,378,761.08** | **1,577,947,607.30** |
| 39301 | Програм хангамж | 2,207,175,000.00 | 2,214,188,219.04 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл- Програм хангамж | (879,986,866.90) | (1,313,130,750.36) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 769,507,340.00 | 769,507,340.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл- Бусад биет бус хөрөнгө | (41,316,712.02) | (92,617,201.38) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **8,287,390,467.12** | **7,313,850,058.47** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **4,021,400.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **4,021,400.00** | **0.00** |
| **41300** | **ӨГЛӨГ** | **4,021,400.00** | **0.00** |
| 41360 | Бусад өглөг | 4,021,400.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 4,021,400.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | **8,283,369,067.11** | **7,313,850,058.46** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 8,283,369,067.11 | 7,313,850,058.46 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 769,507,340.00 | 769,507,340.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 7,066,792,329.15 | 6,097,273,320.50 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 6,879,484,844.09 | 7,017,062,529.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 187,307,485.06 | (919,789,208.65) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 447,069,397.96 | 447,069,397.96 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **8,287,390,467.11** | **7,313,850,058.46** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **94,346,627,046.93** | **96,288,409,570.79** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,339,439,693.48** | **878,751,174.89** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,339,439,693.48 | 878,751,174.89 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 154,000.00 | 86,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 154,000.00 | 86,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 704,356,019.08 | 861,422,829.04 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 634,929,674.40 | 17,242,345.85 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **93,007,187,353.45** | **95,409,658,395.90** |
| 1310 | Улсын төсвөөс | 91,242,023,668.45 | 94,157,490,799.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 91,242,023,668.45 | 94,157,490,799.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,765,163,685.00 | 1,252,167,596.90 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,680,809,685.00 | 1,252,167,596.90 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 74,354,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **93,939,319,561.87** | **97,114,136,783.20** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 93,939,319,561.87 | 97,114,136,783.20 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 7,393,241,696.62 | 7,603,256,023.99 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,879,081,498.03 | 3,137,273,579.88 |
| 210101 | Үндсэн цалин | 2,879,081,498.03 | 2,182,865,223.41 |
| 210102 | Нэмэгдэл | - | 785,261,356.47 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 169,147,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 375,634,608.69 | 409,627,216.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 317,773,647.87 | 341,203,370.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,832,075.58 | 30,536,102.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 19,191,606.25 | 10,381,580.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,866,314.99 | 2,084,602.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,970,964.00 | 25,421,560.58 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 185,794,400.00 | 216,891,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 85,200,000.00 | 89,794,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 74,794,400.00 | 70,200,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 25,800,000.00 | 25,800,000.00 |
| 213304 | Байрны түрээс | - | 31,097,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 237,862,596.41 | 362,922,768.13 |
| 210401 | Бичиг хэрэг | 130,034,750.00 | 145,657,439.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,394,290.00 | 23,514,515.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 40,283,447.39 | 40,647,592.63 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 49,150,109.02 | 151,297,681.50 |
| 210408 | Бараа материал актласны зардал | - | 1,805,540.00 |
| 2105 | Нормативт зардал | 55,160,700.00 | 97,837,255.00 |
| 210502 | Хоол хүнс | 55,160,700.00 | 97,837,255.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 102,946,200.00 | 34,708,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 100,050,000.00 | 10,980,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,896,200.00 | 23,728,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 55,522,785.00 | 39,445,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 55,522,785.00 | 39,445,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,120,250,652.00 | 821,255,236.49 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,108,088,031.00 | 750,976,698.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 8,345,595.00 | 3,705,225.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 631,126.00 | 959,992.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 165,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,137,500.00 | 3,906,921.49 |
| 210807 | Газрын төлбөр | 993,400.00 | 61,541,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,380,988,256.49 | 2,483,295,068.10 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,295,211,413.00 | 1,393,739,296.30 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 96,461,602.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 989,315,241.49 | 1,089,555,771.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **86,546,077,865.25** | **89,510,880,759.21** |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 479,739,888.97 | 3,099,065,019.71 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 479,739,888.97 | 3,098,913,295.71 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 151,724.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 144,205,021.00 | 25,979,327.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 3,150,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 120,014,421.00 | - |
| 213209 | Нэр удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 24,190,600.00 | 22,829,327.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 85,731,682,559.28 | 86,213,225,683.50 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 190,450,396.00 | 172,610,729.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **220,000,000.00** | **94,061,996.24** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **407,307,485.06** | **(825,727,212.41)** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **220,000,000.00** | **94,061,996.24** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | **220,000,000.00** | **94,061,996.24** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 94,061,996.24 |
| 225012 | Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн шилжүүлэх зорилготой хөрөнгө | 220,000,000.00 | - |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | 187,307,485.06 | (919,789,208.65) |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 34,096,140.00 | 447,069,397.96 | 7,008,137,342.10 | 7,489,302,880.06 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (128,652,498.00) | (128,652,498.00) |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 735,411,200.00 | - | - | 735,411,200.00 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 187,307,485.06 | 187,307,485.06 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **769,507,340.00** | **447,069,397,96** | **7,066,792,329.15** | **8,283,369,067.11** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (49,729,800.00) | (49,729,800.00) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **769,507,640.00** | **447,069,397.96** | **7,017,062,529.15** | **8,233,639,267.11** |
| Тайлант үеийн үр дүн | | | (919,789,208.65) | (919,789,208.65) |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **769,507,340.00** | **447,069,397.96** | **6,097,273,320.50** | **7,313,850,058.46** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **93,076,960,901.27** | **95,527,779,625.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **154,000.00** | **86,000.00** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 154,000.00 | 86,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 154,000.00 | 86,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 154,000.00 | 86,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **93,076,806,901.27** | **95,527,693,625.90** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 91,242,023,668.45 | 94,157,490,799.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 91,242,023,668.45 | 94,157,490,799.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,834,783,232.82 | 1,370,202,826.90 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,750,429,232.82 | 1,370,202,826.90 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 74,354,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **93,048,791,199.27** | **95,504,101,425.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **93,048,791,199.27** | **95,504,101,425.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,351,957,062.02** | **5,929,864,450.69** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,748,922,563.23 | 3,014,174,018.61 |
| 210101 | Үндсэн цалин | 1,947,560,576.31 | 1,953,702,708.32 |
| 210102 | Нэмэгдэл | 619,022,602.44 | 895,638,639.76 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 182,339,384.48 | 164,832,670.53 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 349,927,050.88 | 388,764,197.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 238,521,074.66 | 291,517,245.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 27,851,744.10 | 24,414,046.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 22,281,555.21 | 19,531,236.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,570,188.71 | 4,845,606.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 55,702,488.20 | 48,456,063.01 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 185,794,400.00 | 216,891,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 85,200,000.00 | 89,794,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 74,794,400.00 | 70,200,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 25,800,000.00 | 25,800,000.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 31,097,000.00 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 201,186,809.95 | 226,971,441.63 |
| 210401 | Бичиг хэрэг | 98,003,550.00 | 129,234,959.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,962,300.00 | 25,220,770.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 40,718,866.95 | 40,647,592.63 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 44,502,093.00 | 31,868,120.00 |
| 2105 | Нормативт зардал | 55,160,700.00 | 97,837,255.00 |
| 210502 | Хоол хүнс | 55,160,700.00 | 97,837,255.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 125,673,400.00 | 136,886,650.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 100,219,000.00 | 126,206,650.00 |
| 210602 | Тавилга | 7,600,000.00 | 1,900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,854,400.00 | 8,780,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 55,522,785.00 | 39,445,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 55,522,785.00 | 39,445,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,276,535,337.96 | 998,073,817.03 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,272,085,161.96 | 927,795,278.54 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 633,150.00 | 3,705,225.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 631,126.00 | 959,992.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 165,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,137,500.00 | 3,906,921.49 |
| 210807 | Газрын төлбөр | 993,400.00 | 61,541,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,353,234,015.00 | 810,820,371.30 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,249,172,413.00 | 810,820,371.30 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 104,061,602.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **86,696,834,137.25** | **89,574,236,975.21** |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 647,504,918.97 | 3,163,103,077.71 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 647,504,918.97 | 3,098,913,295.71 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 64,189,782.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 126,514,421.00 | 25,979,327.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 3,150,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 120,014,421.00 | - |
| 213209 | Нэр удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,500,000.00 | 22,829,327.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 85,732,364,401.28 | 86,212,543,841.50 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 190,450,396.00 | 172,610,729.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (II=I-II)** | **28,169,702.00** | **23,678,200.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **28,170,602.00** | **23,678,200.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **28,170,602.00** | **23,678,200.00** |
| 223 | **БУСАД ХӨРӨНГӨ** | **28,170,602.00** | **23,678,200.00** |
| 223004 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | **28,170,602.00** | **23,678,200.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)** | **(28,170,602.00)** | **(23,678,200.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)** | **(900.00)** | **-** |
| **15** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **(900.00)** | **-** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **97,023,565,900.00** | **91,058,663,503.29** | **5,964,902,396.71** | **93.9** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **97,023,565,900.00** | **91,058,663,503.29** | **5,964,902,396.71** | **93.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,878,600,000.00** | **4,647,529,605.79** | **231,070,394.21** | **95.3** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл | 3,090,023,100.00 | 2,948,846,968.61 | 141,176,131.39 | 95.4 |
| 210101 | Үндсэн цалин | 1,894,673,800.00 | 1,888,375,658.32 | 6,298,141.68 | 99.7 |
| 210102 | Нэмэгдэл | 1,002,926,300.00 | 895,638,639.76 | 107,287,660.24 | 89.3 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 192,423,000.00 | 164,832,670.53 | 27,590,329.47 | 85.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 417,403,100.00 | 380,201,681.52 | 37,201,418.48 | 91.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 292,802,200.00 | 282,954,729.76 | 9,847,470.24 | 96.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 31,150,200.00 | 24,414,046.15 | 6,736,153.85 | 78.4 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 24,920,200.00 | 19,531,236.39 | 5,388,963.61 | 78.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,230,000.00 | 4,845,606.21 | 1,384,393.79 | 77.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 62,300,500.00 | 48,456,063.01 | 13,844,436.99 | 77.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 185,794,400.00 | 185,794,400.00 | (0.00) | 100.0 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 89,794,400.00 | 89,794,400.00 | (0.00) | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 70,200,000.00 | 70,200,000.00 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 25,800,000.00 | 25,800,000.00 | - | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 126,258,700.00 | 126,178,738.63 | 79,961.37 | 99.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 42,615,600.00 | 39,643,026.00 | 2,972,574.00 | 93.0 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 12,643,300.00 | 14,020,000.00 | (1,376,700.00) | 110.9 |
| 210403 | Шуудан  холбоо, интернэтийн төлбөр | 37,745,000.00 | 40,647,592.63 | (2,902,592.63) | 107.7 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 33,254,800.00 | 31,868,120.00 | 1,386,680.00 | 95.8 |
| **2106** | **Эд хогшил урсгал засварын зардал** | 5,080,000.00 | 5,080,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 5,080,000.00 | 5,080,000.00 | - | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,398,800.00 | 3,354,000.00 | 44,800.00 | 98.7 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,398,800.00 | 3,354,000.00 | 44,800.00 | 98.7 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | 1,050,641,900.00 | 998,073,817.03 | 52,568,082.97 | 95.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 980,126,100.00 | 927,795,278.54 | 52,330,821.46 | 94.7 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,800,000.00 | 3,705,225.00 | 94,775.00 | 97.5 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 994,500.00 | 959,992.00 | 34,508.00 | 96.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 239,800.00 | 165,000.00 | 74,800.00 | 68.8 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 3,940,100.00 | 3,906,921.49 | 33,178.51 | 99.2 |
| 210807 | Газрын төлбөр | 61,541,400.00 | 61,541,400.00 | - | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 92,144,965,900.00 | 86,411,133,897.50 | 5,733,832,002.50 | 93.8 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 92,118,985,900.00 | 86,385,154,570.50 | 5,733,831,329.50 | 93.8 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 91,904,070,000.00 | 86,212,543,841.50 | 5,691,526,158.50 | 93.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 214,915,900.00 | 172,610,729.00 | 42,305,171.00 | 80.3 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 25,980,000.00 | 25,979,327.00 | 673.00 | 100.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,150,000.00 | 3,150,000.00 | - | 100.0 |
| 213209 | Нэр удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,830,000.00 | 22,829,327.00 | 673.00 | 100.0 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **119.00** | **119.00** | **-** | **-** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **119.00** | **119.00** | **-** | **-** |
| 620001 | Удирдах ажилтан | **20.00** | **20.00** | **-** | **-** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | **95.00** | **95.00** | **-** | **-** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | **4.00** | **4.00** | **-** | **-** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **1,370,202,826.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **1,306,013,044.90** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **1,306,013,044.90** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | **-** | 65,327,050.00 |
| 210101 | Үндсэн цалин | - | 65,327,050.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | **-** | 8,562,515.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 8,562,515.60 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | **-** | 31,097,000.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 31,097,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 100,792,703.00 |
| 210401 | Бичиг хэрэг | **-** | 89,591,933.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | - | 11,200,770.00 |
| 2105 | Норматив зардал | - | 97,837,255.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 97,837,255.00 |
| 2106 | Эд хогшил урсгал засварын зардал | - | 155,484,850.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | **-** | 149,884,850.00 |
| 210602 | Тавилга | **-** | 1,900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | **-** | 3,700,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 36,091,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 36,091,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 810,820,371.30 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 810,820,371.30 |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 64,189,782.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 64,189,782.00 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 1,370,202,826.90 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 1,370,202,826.90 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан | - | 1,370,202,826.90 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд аудитор Н.Баттөгөлдөр, ахлах аудитор Б.Нарангэрэл нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Сэржмядаг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/198 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилго нь хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

- Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэх зорилгоор өрхийн амьжиргааны түвшнийг төрийн байгууллагын мэдээллийн санд үндэслэн тодорхойлдог байхаар аргачлалыг шинэчлэн, нэвтрүүлэх;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын статистикийн нэгдсэн платформ бий болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай";
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар".

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар зэрэгт нийцэж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувь 939,393.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 998,836.9 мянган төгрөгөөр буюу 12.0 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, эргэлтийн бус хөрөнгө данснууд байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 174,311.1 | 153,576.9 | (20,734.2) |
| Урьдчилж гарсан зардал | 88,627.6 | 36,588.0 | (52,039.6) |
| Бараа материал | 211,957.5 | 107,387.0 | (104,570.6) |
| БЗЭ бүй эргэлтийн бус хөрөнгө | 537,179.3 | 30,000.0 | (507,179.3) |
| Үндсэн хөрөнгө | 7,275,314.9 | 6,961,001.7 | (314,313.2) |
| **Нийт хөрөнгө** | **8,287,390.5** | **7,288,553.6** | **(998,836.9)** |
| Өр төлбөр | 4,021.4 | - | (4,021.4) |
| Хуримтлагдсан үр дүн | 8,283,369.1 | 7,288,553.6 | (994,815.5) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **8,287,390.5** | **7,288,553.6** | **(998,836.9)** |

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 20,734.2 мянган төгрөгөөр буурсан нь 64,038.1 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагаас шалтгаалсан;
- Урьдчилж гарсан зардал нь өмнөх оноос 52,039.6 мянган төгрөгөөр буурсан;
Бараа материалын дансны эхний үлдэгдлээс 104,570.6 мянган төгрөгөөр буурсан нь ХНХЯ-ны сайдын А/147 дугаар тушаалаар 31,241.8 мянган төгрөгийн тэмдэг, жуух;
Төрийн нарийн бичгийн даргын А/83 дугаар тушаалаар 24,372.7 мянган төгрөгийн бараа материалыг акталсан, 48,717.6 мянган төгрөгийн салбарын хуулийн эмхэтгэл, гарын авлагыг тараасан нь нөлөөлсөн байна.
- Бусад эргэлтийн бус хөрөнгө данс буурсан нь төрийн нарийн бичгийн даргын А/151 дугаар тушаалаар 507,179.3 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд шилжүүлсэн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 314,313.2 мянган төгрөгөөр буурсан нь харьяа байгууллагуудад 118,618.7 мянган төгрөгийн 2 автотээврийн хэрэгсэл, 72,633.7 мянган төгрөгийн компьютер техник хэрэгслийг шилжүүлэн өгч, ТӨБЗГ-ын 520 дугаар тогтоолоор 498,298.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан;
- Өр төлбөр дансны өмнөх оны байгууллагад өгөх өр төлбөрийг барагдуулж 4,021.4 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2021 оны урсгал санхүүжилтийг 370,791,164.3 мянган төгрөгөөр төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас урсгал санхүүжилтийг 97,296,269.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор бараа үйлчилгээний зардлыг 42,495.1 мянган төгрөгөөр бууруулж, 97,023,565.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөр, 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталжээ. Гүйцэтгэлээр урсгал зардалд 97,023,565.9 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 91,058,663.5 мянган төгрөг зарцуулж, 5,964,902.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн 93.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 91,058,663.5 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардал 178,377.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 79,9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 52,568,0 мянган төгрөг, Засгийн газрын гадаад, дотоод шилжүүлэг 5,733,831.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.
Нэмэлт санхүүжилтийн дансанд гадаад төсөл хөтөлбөрөөс 1,370,202.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.
Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 1,306,013.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 64,189.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, түүнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 93.8 хувийн биелэлттэй байна. Яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажилласан байна.

- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээнд 4 арга хэмжээ хэрэгжсэн байна.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 3 хэсэг зорилт, арга хэмжээний нийт 200 арга хэмжээ хэрэгжсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал гараагүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.
Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 2021 онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10 гүйлгээ, зарлагын 1,208,558.7 мянган төгрөгийн 13 гүйлгээг

мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4. *таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг;* 6.4.5."*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*;" заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Төсвийн хэмнэлтийн талаар

Шатахуун болон шуудан холбооны төсвийг 4,279.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол. "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" заасанд нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах албан шаардлага өгөх

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 албан шаардлага, 5 зөвлөмжийн 100 хувийн биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, Үндэсний аудитын газарт 2021 онд 4/1660 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

*Хүснэгт-3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж,акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 4 | 282,629.0 | 3 | 282,629.0 | 1 | - | 90 |
| Зөвлөмж | 5 | 55,813.0 | 5 | 55,813.0 | - | - | 100 |
| **Нийт дүн** | **9** | **338,442.0** | **9** | **338,442.0** | - | - | 95 |

Өмнөх аудитаар и баримтын албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлсэн, шилэн дансны мэдээлэл хоцроосон албан шаардлагыг 90 хувь биелүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй тул гадаадын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл буюу нэмэлт санхүүжилтийн зорилго, хүрсэн үр дүн, өгөөжийг тодорхойлох, зарцуулалтад нь тавигдах хяналт сул байгааг цаашид анхаарах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,193,033.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 693,532.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 468,275.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 31,224.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүй шилжин ирсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг дансанд бүртгээгүй 116,150.1 мянган төгрөг;
- Бусад үндсэн хөрөнгөнд дансанд бүртгэлтэй нийтийн бие засах газар, худгийн элэгдлийн зардлыг 25,964.7 мянган төгрөгөөр илүү тооцсон;
- Үнэ төлбөргүй шилжиж ирсэн үндсэн хөрөнгийн дүн нь санхүүгийн үр дүнгийн тайлангаас үндсэн хөрөнгийн тодруулгын дүн зөрүүтэй 4,158.0 мянган төгрөг;
- Нөөцийн бараа дансанд бүртгэсэн эргэлтийн бус хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын тодруулгын хэсэгт тусгаагүй 537,179.3 мянган төгрөг;
- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дансанд нэр данс зөрүүтэй гүйлгээ, ХЧТА тэтгэмжийг бүртгэн тайлагнасан 2,588.2 мянган төгрөг;
- Балансаас балансt шилжиж ирсэн 7,492.4 мянган төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг шүүгээ, санхүүгийн 2 программыг данс бүртгэлд тусгаагүй алдааг залруулсан.

### 4.2. Албан шаардлага

1. Бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 19,698.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн шинж чанартай 6 нэр төрлийн 7,997.1 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэн зарлагадсан.
- Аж ахуйн материал дансанд 18 нэр төрлийн, бусад хангамжийн материал дансанд 8 нэр төрлийн нийт 11,701.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 “үнэн зөв байх”, УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах биет хөрөнгө, ...б/нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” Төрийн өмчийн болон орон нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйл. Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах, 31.1 “худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийг бараа материал данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх, хөрөнгийг зөв ангилан бүртгэж байх, Албан шаардлага өгөх

2. Үндсэн хөрөнгө дансанд элэгдлээрээ анхны өртгөө 67 ширхэг нөхсөн 423,478.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн болон орон нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйл. Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах. 31.3. 2. "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай

зөвшилцөн тогтоох", 31.3.3 "засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлэх, эсвэл данснаас хасах саналыг ТӨБЗГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэх албан шаардлага өгөх

3. Албан хаагчдын нэмэгдэл хөлстэй холбоотой нийт 25,098.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Үйлчилгээний албан хаагчдад цагийн бүртгэлийг дутуу хөтөлсөн, ерөнхий нягтлан бодогчийн гарын үсэггүй, анхан шатны баримтын иж бүрдэлгүй 21,638.5 мянган төгрөгийн нэмэгдэл хөлсийг тооцож олгосон;
- Захиргааны албан хаагчдад илүү цаг ажилласан нэмэгдэл хөлсийг 3,459.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмаар баталсан Нэмэгдэл хөлс тооцож олгох журмын 3.Нэмэгдэл хөлс олгох. “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ”, 3.3. “илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтийн амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүртгэл тооцоог батлагдсан маягтаар хөтлөн албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулах, холбогдох эрх зүйн зохицуулалтаар заасан хэмжээнд нэмэгдэл хөлсийг тооцох албан шаардлага өгөх

**4.3 Зөвлөмж**

**Балансын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Бараа материалын дансаар дамжуулалгүй авлагын данснаас 18,032.6 мянган төгрөгийн материал, урьдчилж гарсан зардал данснаас 13,191.9 мянган төгрөгийн түлш шатхууныг зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1. “аж ахуйн бүх ажил, гүйлгээ хийх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Зөвлөмж:*

Ажил гүйлгээг бараа материалын дансаар бүртгэн тайлагнах, улирал бүр хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр, код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| **Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар** | | | | | | | | | | | | | | | |
| 1 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 19,698.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:<br>-Үндсэн хөрөнгийн шинж чанартай 6 нэр төрлийн 19,698.6 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэн зарлагадсан.<br>-Аж ахуйн материал дансанд 18 нэр төрлийн, бусад хангамжийн материал дансанд 8 нэр төрлийн нийт 11,701.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн; | Үндсэн хөрөнгийг бараа материал данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх, хөрөнгийг зөв ангилан бүртгэж байх, | 1 | 19,698.6 | | | | | 1 | 19,698.6 | | | | |
| 2 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Үндсэн хөрөнгө дансанд элэгдлээрээ анхны өртгөө 67 ширхэг нөхсөн 423,478.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. | Эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлэх, эсвэл данснаас хасах саналыг ТӨБЗГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэх. | 1 | 423,478.8 | | | | | 1 | 423,478.8 | | | | |
| 3 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Албан хаагчдын нэмэгдэл хөлстэй холбоотой нийт 25,098.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:<br>-Үйлчилгээний албан хаагчдад цагийн бүртгэлийг дутуу хөтөлсөн, ерөнхий нягтлан бодогчийн гарын үсэггүй, анхан шатны баримтын иж бүрдэлгүй 21,638.5 мянган төгрөгийн нэмэгдэл хөлсийг тооцож олгосон; | Бүртгэл тооцоог батлагдсан маягтаар хөтлөн албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулах, холбогдох эрх зүйн зохицуулалтаар заасан хэмжээнд нэмэгдэл хөлсийг тооцох | 1 | 25,098.4 | | | | | 1 | 25,098.4 | | | | |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | -Захиргааны албан хаагчдад илүү цаг ажилласан нэмэгдэл хөлсийг 3,459.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна. | | | | | | | | | | | | | |
| 4 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Бараа материалын дансаар дамжуулалгүй авлагын данснаас 18,032.6 мянган төгрөгийн засварын материал, урьдчилж гарсан зардал данснаас 13,191.9 мянган төгрөгийн түлш шатахууныг зардлын дансанд хаасан | НББОУС дагуу бүртгэл хөтлөх | 1 | 31,224.5 | | | | | | | | | 1 | 31,224.5 |
| 5 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Үнэ төлбөргүй шилжин ирсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг бүртгээгүйгээс санхүүгийн байдлын тайланд биет хөрөнгийн дүн буруу илэрхийлэгдсэн | НББ стандартын дагуу бичилтийг хийх | 1 | 116,150.1 | 1 | 116,150.1 | | | | | | | | |
| 6 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Бусад үндсэн хөрөнгийн элэгдлийг тайлант онд 100%-аар тооцож санхүүгийн үр дүнгийн тайланд нөлөөлсөн | НББ стандартын дагуу бичилтийг хийх | 1 | 25,964.7 | 1 | 25,964.7 | | | | | | | | |
| 7 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Үндсэн хөрөнгийн тодруулгад үнэ төлбөргүй шилжиж ирсэн үндсэн хөрөнгийн дүн санхүүгийн үр дүнгийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн / | НББ стандартын дагуу бичилтийг хийх | 1 | 4,158.0 | 1 | 4,158.0 | | | | | | | | |
| 8 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Нөөцийн бараа дансанд бүртгэсэн эргэлтийн бус хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын тодруулгын хэсэгт тусгаагүй. | НББ стандартын дагуу бичилтийг хийх | 1 | 537,179.3 | 1 | 537,179.3 | | | | | | | | |
| 9 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дансанд нэр данс зөрүүтэй гүйлгээ, ХЧТА тэтгэмжийг бүртгэн тайлагнасан | НББ стандартын дагуу бичилтийг хийх | 1 | 2,588.2 | 1 | 2,588.20 | | | | | | | | |
| 10 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Балансаас балансt шилжиж ирсэн 2 ширхэг тумба /479180/, Санхүүгийн программыг /7013219.04/данс бүртгэлд тусгаагүй | НББ стандартын дагуу бичилтийг хийх | 1 | 7,492.4 | 1 | 7,492.4 | | | | | | | | |
| **Дүн** | | | | **10** | **1,193,033.0** | **6** | **693,532.7** | **-** | **-** | **3** | **468,275.8** | **-** | **-** | **1** | **31,224.5** |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | | | | | | | | | | | |
| 13 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Шилэн дансны мэдээллийн санд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн, 10 ширхэг, зарлагын 1,208,558.7 мянган төгрөгийн 13 ширхэг мэдээллийг тус тус байршуулаагүй байна. | Шилэн дансны хэрэгжилтийг баримталж ажиллах | 1 | 1,208,558.7 | | | | | | | 1 | 1,208,558.7 | | |
| 14 | ХНХЯам АХГ2022/225/ НА-СТА-ТШЗ | Шатахуун болон шуудан холбооны зардлын төсвийг хэтрүүлэн зарцуулсан | Батлагдсан төсөвт багтаан зарцуулах | 1 | 4,279.3 | | | | | 1 | 4,279.3 | | | | |
| Дүн | | | | 2 | 1,212,838.0 | | | | | 1 | 4,279.3 | 1 | 1,208,558.7 | | |
| **Нийт дүн** | | | | **12** | **2,405,871.0** | **6** | **693,532.7** | **-** | **-** | **4** | **472,555.1** | **1** | **1,208,558.7** | **1** | **31,224.5** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 252/А0160459 Улаанбаатар хот

АХГ-2022/225/НА-СТА-ТШ13

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахуун болон шуудан холбооны төсвийг 4,279,300.00 төгрөгөөр хэтрүүлсэн

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол. 1.1"үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх..." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.5 "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахуун болон шуудан холбооны зардлын төсвийг хэтрүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, нягтлан бодогч Г.Ганцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Б.СЭРЖМЯДАГ |
| АХЛАХ АУДИТОР | Б.НАРАНГЭРЭЛ |
| АУДИТОР | Н.БАТТӨГӨЛДӨР |

9006109
9019120396

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-242.Docx

0010800764

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 256/А0160459 Улаанбаатар хот

АХГ-2022/225/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10 гүйлгээ, зарлагын 1,208,558,700.00 төгрөгийн 13 гүйлгээг мэдээлээгүй; өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4. *таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг;* 6.4.5.”*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;*” заалтад нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ*”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчил давтан гаргасан тул Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нягтлан бодогч Г.Ганцэцэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаярт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Б.СЭРЖМЯДАГ |
| АХЛАХ АУДИТОР | Б.НАРАНГЭРЭЛ |
| АУДИТОР | Н.БАТТӨГӨЛДӨР |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-274.Docx

0010800837

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 246/A0160459 Улаанбаатар хот
АХ Г-2022/220/НА-СТА-7ШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан дагуу хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Ерөнхий нягтлан бодогчийн гарын үсэггүй, цагийн бүртгэлийн бүрдэл дутуу баримтаар үйлчилгээний албан хаагчдад 21,638,500.00 төгрөгийн нэмэгдэл хөлсийг тооцон олгосон,
2. Захиргааны албан хаагчдад илүү цаг ажилласан нэмэгдэл хөлсийг 3,459,900.00 төгрөгөөр хэтрүүлэн нийт 25,098,400.00 төгрөг олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмаар баталсан нэмэгдэл хөлс тооцож олгох журам. 3. "Нэмэгдэл хөлс олгох. Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" 3.3. "илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтийн амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу захих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Илүү ажилласан цагийн хөлсийг "Нэмэгдэл хөлс олгох тооцооны хуудас"-ыг хөтлөөгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, нягтлан бодогч Г.Ганцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ
АХЛАХ АУДИТОР Б.НАРАНГЭРЭЛ
АУДИТОР Н.БАТТӨГӨЛДӨР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-244.Docx

0010800768

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 №245/А0160459 Улаанбаатар хот

АХГ-2022/225/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-ийн дагуу хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгө дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 67 ширхэг 423,478,800.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь “Төрийн өмчийн болон орон нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйл. Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах. 31.3. 2. "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;", 31.3.3. "засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах;" заалтад нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1 “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгө дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг ТӨБЗГ-т хандан шийдвэрлүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, нягтлан бодогч Г.Ганцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Б.СЭРЖМЯДАГ |
| АХЛАХ АУДИТОР | Б.НАРАНГЭРЭЛ |
| АУДИТОР | Н.БАТТӨГӨЛДӨР |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Hang_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-243.Docx

00108C0766

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 260/А0160459 Улаанбаатар хот

АХГ-2022/225/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн шинж чанартай 6 нэр төрлийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэн зарлагадсан.
- Аж ахуйн материал дансанд 18 нэр төрлийн, бусад хангамжийн материал дансанд 8 нэр төрлийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн нийт 19,698,600.00 төгрөг

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл; 5.1. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална. 5.1.4. үнэн зөв байх, УСНББОУС 17. Үндсэн хөрөнгө гэдэг нь дараахь биет хөрөнгө: ...б/нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм./, Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл. "Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах.", 31.1 "худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх" гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтахгүй ажиллаж биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, нягтлан бодогч Г.Ганцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ
АХЛАХ АУДИТОР Б.НАРАНГЭРЭЛ
АУДИТОР Н.БАТТӨГӨЛДӨР

9006109
9019120396

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-237.Docx

0010800754